## НИЙСЛЭЛИЙН АГААР,ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН
## НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ

2024.01.02

| Дугаар | Төлөвлөгөөний дугаар | ХБТББ-т тусгагдсан зорилт үйл ажиллагаа | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ(сая төгрөг) | Суурь түвшин | Зорилтод түвшин, үр дүн (Хөрөнгийн хэмжээ эх үүсвэр ) | | | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв (Сая.төг) | Төсвийн Гүйцэтгэл (сая.төг) | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | | | | | | | | |
| 5.2 Агаар, орчны бохирдлыг бууруулж, байгальд ээлтэй, үр ашигтай хэрэглээ нэмэгдүүлэх замаар эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлнэ. | | | | | | | | | | | | | |
| 1 | 4.2.1 | НХТЖҮЧ-6.2.1, НЗДҮАХ-5.2.1 ХАХТ-5.2.1.1 | Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн тогтоож, түүнд мөрдөх журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавина. | 2023 | НАОБТГ | - | - | Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн тогтоож, түүнд мөрдөх журмыг шинэчлэн баталсан. | Журмыг шинэчлэн баталж, хэрэгжилтэд хяналт тавина. | - | - | Агаарын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1,15.3 дэх зүйлд заасанчлан агаарын чанарыг сайжруулах бүсийг жил бүр шинэчлэн баталдаг. “Агаарын чанарыг сайжруулах бүс, түүнд мөрдөх журам”-ыг шинэчлэн Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг даргын хамтарсан 2022 оны 10 сарын 17-ны өдрийн А/424-А1353 дугаартай тушаал, захирамжийг батлуулсан. Энэхүү тушаал, захирамжид Монгол Улсын Засгийн газрын 2022-2023 оны “Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 223 дугаар тогтоолоор | 70 |

## НИЙСЛЭЛИЙН АГААР, ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН 2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

2023.06.05

Улаанбаатар хот

| № | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|
| | **Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал** | | |
| 1.1 | Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн; | Байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэлийг албан ёсны https://aprd.ub.gov.mn/ вэбсайтын байгууллагын тухай цэсний байгууллагын танилцуулга, стратегийн төлөвлөгөө, дэд цэсэнд ойлгомжтой байршуулсан. Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг тайлан цэсний газрын тайлан дэд цэсэд https://aprd.ub.gov.mn/ байршуулсан. | 100% |
| 1.2 | Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг; | Газрын чиг үүрэг, бүтэц зохион байгуулалт байгууллагын албан ёсны https://aprd.ub.gov.mn/ вэбсайтын байгууллагын тухай цэсний байгууллагын танилцуулга, бүтэц, зохион байгуулалт дэд цэсэд байршуулсан. Хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг вэбсайтын нүүрэн хэсгийн зүүн доод буланд байршуулсан. Мөн зохион байгуулалтын бүтцийн схемийг мэдээллийн самбарын хүний нөөц буланд шинэчлэн байршуулсан. | 100% |
| 1.3 | Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж; | Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээллийг тайлан цэсний газрын тайлан дэд цэсэд байршуулсан. Мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмжийг байгууллагын албан ёсны https://aprd.ub.gov.mn/ вэбсайтын ил тод байдал цэсэнд санхүүгийн тайлан, аудитын тайлан, байгууллагынг ил тод байдал дэд цэсэд оны дарааллаар байршуулсан. | 100% |
| 1.4 | Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан; | Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланг ил тод байдал цэсний байгууллагын ил тод байдал дэд цэсний байгууллагын дотоод хяналт буланд байршуулсан. | 100% |
| 1.5 | Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан; | Байгууллагын жилийн эцсийн тайланг албан ёсны https://aprd.ub.gov.mn/ вэбсайтын газрын тайлан цэсэнд оны дараалллаар байршуулсан. | |
| 1.6 | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт; | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн актыг байгууллагын албан ёсны https://aprd.ub.gov.mn/ вэбсайтын хууль эрх зүй цэсэнд:<br>- Монгол улсын хууль<br>- ОББҮХ-ны тогтоол<br>- Журам<br>- Нийслэлийн Засаг даргын захирамжууд | 100% |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | Налайх дүүргийн гэр хорооллын 8 хорооны 7,691 өрхийг агаарын чанарыг сайжруулах бүсэд хамруулсан. Мөн Налайх дүүргийн 33 хяналтын ажилтан орчны бохирдлыг бууруулахад идэвхтэй оролцож, иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэн хяналт тавин хэрэгжилтийг хангах ажилласан. 2023-2024 оны Агаарын чанарыг сайжруулах бүс, түүнд мөрдөх журамыг батлуулахаар төслийг бэлтгэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас санал авч, зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна. | |
| 2 | 4.2.2 | НХТЖҮЧ-6.2.1, НЗДҮАХ-5.2.1 ХАХТ-5.2.1.3 | Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд сайжруулсан түлшний нөөц бүрдүүлж, борлуулалтын цэгийн тоог нэмэглүүлэн, түгээх, тээвэрлэх, борлуулах үйл ажиллагаанд | 2023 | НАОБТГ | Нийслэлийн төсөв | 50,700.0 | 730,000 тн сайжруулсан түлш борлуулсан. | 768,000 тн түлш сайжруулсан түлш борлуулна. | 37,567.8 | 22,9 тэрбум | **Сайжруулсан шахмал түлшний тээвэрлэлт:** Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Хөрөнгө гаргах, эрх шилжүүлэх тухай” А/168 дугаар захирамжаар нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд сайжруулсан шахмал түлш тээвэрлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулж ажиллахыг Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газарт даалгасан. Энэхүү ажлын хүрээнд нийслэлийн 7 дүүргийн хэмжээнд 2023-2024 онд сайжруулсан шахмал түлш тээвэрлэх 31 багц ажлыг | 100 |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | дэмжлэг үзүүлж хяналт тавина. | | | | | | | | | www.tender.gov.mn-д зарлаж 31 тээврийн компанийг хуулийн хүрээнд сонгон шалгаруулж "Сайжруулсан шахмал түлш тээвэрлэх гэрээ"-г байгуулсан. 2023 онд 31 тээврийн компани нь Баруун болон Зүүн бүсийн үйлдвэрээс борлуулалтын цэг, агуулах, агуулахаас борлуулалтын цэг хүртэл нийт 583,439,025 тонн сайжруулсан шахмал түлшийг тасралтгүй тээвэрлэн ажиллаж байна. Тус газар нь сайжруулсан шахмал түлш тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад тээвэрлэсэн түлшний тонн хэмжээ болон гүйцэтгэлийг хянан 2023 онд 13,2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгон хяналт тавин ажиллаж байна.<br>**Сайжруулсан шахмал түлшний борлуулалт:**<br>2023-2024 оны халаалтын улиралд нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд сайжруулсан шахмал түлш борлуулах 650 борлуулалтын цэгийг нээн ажиллуулахаар төлөвлөсөн. Энэхүү ажлын хүрээнд "Таван толгой түлш" ХХК нь 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд 650 сайжруулсан шахмал түлш борлуулах борлуулалтын | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | цэгийг нээн ажиллуулж гэр хорооллын 203,683 айл өрхийг 340,496 тонн сайжруулсан шахмал түлшээр хангаж, борлуулалтын урамшууллын зардалд нийт 5,1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож ажилласан.<br>**Сайжруулсан шахмал түлшний нөөцлөлт:**<br>Нийслэлийн Засаг даргын 2023 оны "Хөрөнгө гаргах, эрх шилжүүлэх тухай" А/167 дугаар захирамжаар 2023-2024 оны халаалтын улиралд гэр хорооллын айл өрхийн хэрэгцээнд зориулж 120 мянган тонн сайжруулсан шахмал түлшний нөөц бүрдүүлэх ажлын хүрээнд газрын даргын тушаалаар агуулах түрээслэх, сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулан 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн зохион байгуулж, шаардлага хангаж түлш нөөцлөх боломжтой 53 агуулахыг Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар болон "Таван толгой түлш" ХХК-тай хамтран сонгон шалгаруулж ажилласан. 2023 онд шаардлага хангаж түлш нөөцлөх боломжтой 53 агуулах, нийслэлийн өмчийн 4 агуулахад нийт 120,000 тонн сайжруулсан шахмал түлшний | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | нөөц бүрдүүлж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай “Сайжруулсан шахмал түлш нөөцлөх, гурвалсан гэрээ”-г байгуулан хяналт тавин 4.6 тэрбум төгрөгийн агуулахын түрээсийн санхүүжилтийг олгон ажилласан. | |
| 3 | 4.2.3 | НХТЖҮЧ-6.2.1, НЗДҮАХ-5.2.1 ХАХТ-5.2.1.4 | Сайжруулсан түлшний агуулах барьж үйл ажиллагааг жигждрүүлнэ. | 2023 | НАОБТГ | - | - | 2021 онд сайжруулсан түлшний 5 агуулах баригдсан. | Шинээр 1 агуулах нэмж барих газрын асуудлыг шийдвэрлэсэн байна. | - | - | Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Эрх шилжүүлэх тухай” А/1026 дугаар захирамж батлагдан сайжруулсан шахмал түлшний агуулах барих, худалдан авах төсөл арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг үүрэг болгосон. Захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу агуулах худалдан авах ажлыг 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр нээлттэй зарлаж, сонгон шалгаруулсан боловч гомдол гарч шүүхийн шатанд хянагдан дахин санхүүжилт авах хүсэлтийг Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороонд хүргүүлсэн боловч Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 11 дүгээрсарын 01-ний өдрийн 396 дугаар тогтоолоор татан буулгах болсонтой холбогдуулан тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон. | 90 |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | 4.2.4 | МУХЖТ-4.1.7 НХТЖҮЧ-6.2.2, НЗДҮАХ-5.2.1 ХАХТ-5.2.1.5 | Агаарын бохирдлыг бууруулах цогц арга хэмжээ авч, агаар дахь PM2.5, PM10 тоосонцрын агууламжийг бууруулна. | 2023 | НАОБТГ | Нийслэлийн төсөв | | 44/89 | 39/78 | 50.0 | 25.0 | 2023 оны хүйтний улирал 11 дүгээр сарын Улаанбаатар хотын агаар дахь агаар бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үе буюу 2022 оны 11 дүгээр сарын дундаж агууламжтай харьцуулахад PM10 тоосонцор 10 мкг/м3-ээр буюу 10%-иар, хүхэрлэг хий (SO2) нь 21 мкг/м3-ээр буюу 25%-иар тус тус бага байна. Харин PM2.5 тоосонцор 3 мкг/м3-ээр буюу 5%-иар их байна.<br>/хүйтний улирлын 12 сарын мэдээ 2024.01 дүгээр сард гарна./ | 100 |
| 5 | 4.2.5 | МУХЖТ-4.1.7 НХТЖҮЧ-6.2.2, НЗДҮАХ-5.2.1 ХАХТ-5.2.1.5 | Хотын стандарт, норм, дүрмийг олон улсын жишигт нийцүүлэн болосруулж мөрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Агаарын чанарын стандарт"-ыгшинэчлэн боловсруул | 2023 | НАОБТГ | 50.0 | | Хотын стандартын баримт бичиг багц | 1 | - | - | "Агаарын чанарын стандарт"-ыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг БОАЖЯ, УЦУОШГ, Хотын стандартын газруудтай хамтран байгуулахаар ажилласан бөгөөд тус стандартыг "Гэрийн зуухны стандарт" болгон өөрчлөн боловсруулж, төслийг 2023 оны 09 дүгээр сарын 21-ний 1/628 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>Уг стандартыг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд Хотын стандартын газарт 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 1/468 тоот албан бичгээр ажлын хэсэгт орох албан хаагчдын нэрсийг хүргүүлсэн. | 70 |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ах ажлыг эхлүүлнэ. | | | | | | | | | Тус ажлын хэсгийн хуралдаанаар Жайка Олон Улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын Агаарын бохирдолын хяналтын чадавхийг бэхжүүлэх төслийн” хүрээнд боловсруулсан “Гэрийн зуухны хаягдал утааны хийн хэмжилтийн гарын авлагыг стандарт болгох тухай хэлэлцэж төслийг 2023 оны 09 дүгээр сарын 21-ний 1/628 тоот албан бичиг боловсруулан хүргүүлсэн. Хотын стандартын газар нь тусдаа MNS стандартыг батлах эрх бүхий байгууллага биш бөгөөд тус байгууллагад стандартын өөрчлөлт хийх санал оруулсан стандартыг удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцээд дэмжигдсэн төслийг Стандарт хэмжил зүйн газарт хүргүүлдэг. Манай байгууллагаас хүргүүлсэн “Гэрийн зуухны хаягдал утааны хийн хэмжилтийн гарын авлага”-ыг стандарт болгох төслийг удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэхээр хүлээгдэж байгаа тул тус заалтын хэрэгжилт удаашралтай байна. | |
| 6 | 4.2.6 | НХТЖҮ Ч-6.2.2, | Шахмал түлш | 2023 | НАОБ ТГ | | | 20 | 20 | 20.0 | - | Тус ажлын хүрээнд лабораторийн шинжилгээнд 39 | 100% |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | НЗДҮАХ-5.2.1 ХАХТ-5.2.1.6 | үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавих | | | | | | | | | дээж авч, 18 удаа хяналт шалгалт хийсэн байна. Үүнд: Урьдчилан сэргийлэх болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын удирдамжийн дагуу "Таван толгой түлш" ХХК-ийн баруун, төв болон зүүн бүсийн үйлдвэрийн үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор хуваарийн дагуу шахмал түлшний-27, мидлингийн-5, барьцалдуулагчийн-7 дээж аван Шинжлэх Ухааны Хими, химийн технологийн хүрээлэн, Ашигт малтмалын газрын тосны газрын лабораторид хүргүүлж, улсын байцаагчийн 14 дүгнэлт гаргаж, улсын байцаагчийн 3 заалттай албан шаардлага 1 удаа хүргүүлэн биелэлтэд хяналт тавин ажилласан. | |
| 7 | 4.2.7 | НХТЖҮЧ-6.2.2, НЗДҮАХ-5.2.1 ХАХТ-5.2.1.7 | Уурын болон 100 кВт-аас дээш хүчин чадалтай усан халаалтын зуух ашиглагч, дулаан, цахилгаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж | 2023 | НМХГ | Нийслэлийн төсөв | - | 160 аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийсэн. | 160 аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийсэн байна. | 20.0 | - | Уурын болон 100кВт-аас дээш хүчин чадалтай усан халаалтын зуух ашиглагч аж ахуйн нэгж, байгууллагын 107 зуух, дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагын 168 зууханд нийт 275 ААНБ-ын халаалтын зууханд хяналт шалгалт хийлээ. Үүнд: БОАЖЯ-ны салбарын ерөнхий байцаагчийн баталсан 01/07 дугаартай урьдчилан сэргийлэх удирдамжийн хүрээнд мөн Нийслэлийн Засаг | 100% |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийж, үйл ажиллагааг сайжруулна. | | | | | | | | | даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, агаар орчны бохирдлын асуудал хариуцсан орлогчийн баталсан агаар бохирдуулагч томоохон эх үүсвэр ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийж магадлан итгэмжлэхийн ажлыг явуулж 180 объектын халаалтын зуух болон баримт бичигт хяналт шалгалт хийж нийт 39 аж ахуйн нэгжид 14650 нэгжтэй тэнцэх торгууль [illegible] хуулийн холбогдох заалтын дагуу хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн.<br>**Төлөвлөгөөт хяналт шалгалт:**<br>БОАЖЯ-ны салбарын ерөнхий байцаагчийн баталсан 01/09 дугаартай төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамжийн хүрээнд нийт 75 аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийснээс зөрчилтэй 13 аж ахуйн нэгж, байгууллагад Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтийн дагуу 6500 нэгжтэй тэнцэх торгууль ногдуулж зөрчлийг арилгуулан улсын байцаагчийн албан даалгавар хүргүүлэн биелэлтэд хяналт тавьж ажиллаж байна.<br>Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны даргын | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | баталсан А/05 тоот удирдамжийн дагуу Эрчим хүч үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын уурын зуухнаас ялгарах түгээмэл тархацтай бохирдуулагч бодисын хэмжээг бууруулах, түүхий нүүрс хэрэглэх хэрэгжилтийг хангуулах хүрээнд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Экологийн цагдаагийн алба, Хэсэгчилсэн инженер хангамжийн удирдах газартай хамтран нийслэлийн 7 дүүргийн нутаг дэвсгэрт дулаан түгээх үйл ажиллагаа эрхэлж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч 50 аж ахуйн нэгж, байгууллагуудын халаалтын зууханд хяналт шалгалт, үзлэг хийж, үлдэгдэл түүхий нүүрсний судалгааг гаргаж, улсын байцаагчийн 2 заалттай албан шаардлагыг 3 аж ахуйн нэгжид хүргүүлэн ажилласан.<br>-Нийслэлийн Засаг даргын А/200 захирамжийн хүрээнд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Экологийн цагдаагийн алба, Хэсэгчилсэн инженер хангамжийн удирдах газартай хамтарсан хяналт шалгалтаар тусгай зөвшөөрөл эзэмшигч 35 | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад халаалтын зуухны засвар үйлчилгээ болон холбогдох бичиг баримтын бүрдэлд хяналт шалгалт хийж Хэсэгчилсэн инженер хангамжийн удирдах газарт улсын байцаагчийн 2 заалттай албан шаардлага хүргүүлэн зөрчлийг арилгуулсан.<br>Мөн Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэж буй тоосгоны үйлдвэрүүдэд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу 57 аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийснээс зөрчилтэй 8 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу 10350 нэгжтэй тэнцэх хэмжээний торгууль ногдуулж улсын байцаагчийн албан даалгавар хүргүүлэн биелэлтэд хяналт тавин ажиллаж байна. | |
| 8 | 4.2.8 | НХТЖҮЧ-6.2.2, НЗДҮАХ-5.2.1 ХАХТ-5.2.1.8 | Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоо, хяналтын цэгүүдэд түүхий нүүрсний хяналт, | 2023 | НАОБТГ НЦГ НОБГ | - | - | 7 товчоонд хяналт хийнэ | 9 товчоонд хяналт хийсэн байна. | - | - | **Ато тээврийн шалган нэвтрүүлэх товчооны мэдээ:** 2023.01.01-12.28-ны өдрийг хүртэлх хугацаанд Эмээлт, Өлзийт, Гүнт, Городок, 5 толгой, Баруун туруун, 4-р зөрлөг Авто тээврийн шалган нэвтрүүлэх 7 товчоонд Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар, Онцгой, Мал эмнэлэг, | 100% |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шалгалтыг үргэлжлүүлэн хийнэ. | | | | | | | | | Цагдаагийн байгууллагаас 26 албан хаагч үүрэг гүйцэтгэсэн. Шалгалтын хүрээнд Улаанбаатар хотоос 273665 тээврийн хэрэгслээр 512859 иргэн гарч, 274083 тээврийн хэрэгслээр 509089 иргэн Улаанбаатар хот руу нэвтэрлээ. 3228 тээврийн хэрэгслээр 90721,67 тн зөвшөөрөлтэй нэвтэрсэн түүхий нүүрс, 4007 тээврийн хэрэгслээр 123383,3 тн дамжин өнгөрсөн түүхий нүүрс, Үүр үйлдвэрлэгчийн зөвшөөрөлтэй 234 тээврийн хэрэгслээр 6172,24 тн мидлинг нэвтрүүлсэн байна.<br>Засгийн газрын 62, 223 дугаар тогтоолын хүрээнд зөвшөөрөлгүй 37,075 тн түүхий нүүрс тээвэрлэсэн 5 зөрчил илрүүлэн Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу арга хэмжээ авч, зөрчлийг арилгуулсан. | |
| 9 | 4.2.9 | НХТЖҮЧ-6.2.2, НЗДҮАХ-5.2.2 ХАХТ-5.2.2.1 | Авто замын хөдөлгөөнд оролцож буй нийтийн болон ачаа тээврийн хэрэгслийн хаягдал утааны агууламжи | 2023 | НАОБТГ | Нийслэлийн төсөв | 30.0 | 120 нийтийн болон ачаа тээврийн хэрэгслийн хаягдал | 450 нийтийн болон ачаа тээврийн хэрэгслийн хаягдал | 30.0 | - | Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар, "Авто тээврийн үндэсний төв" ТӨҮГ, Тээврийн Цагдаагийн албаны холбогдох албан хаагчид хамтран 2023.01.01-01.05-ны өдөр болон 04 дүгээр сарын 06-ны өдрүүдэд Сүхбаатар дүүргийн 32-ын тойргийн нутаг дэвсгэр, Чингэлтэй дүүргийн 39 дүгээр | 100% |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | йг тодорхойлж, стандартад нийцүүлэх, хяналт тавих ажлыг үргэлжлүүлнэ. | | | | | утааны агууламжийг тодорхойлох хяналт шалгалт хийсэн байна. | утааны агууламжийг тодорхойлох хяналт шалгалт хийнэ. | | | сургууль орчмоор, Баянгол дүүргийн 3, 4 хороолол, Баянзүрх дүүргийн ЗДТГ-ын нутаг дэвсгэрт замын хөдөлгөөнд оролцож буй 93 автомашинд, тээврийн хэрэгслээс ялгарах хаягдал утаан дахь хорт бодис зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхэд хяналт, шалгалт, хэмжилт хийн ажилласан.<br>Уг хэмжилтээр дизель түлш ашигладаг 62, автобензин ашигладаг 31 тээврийн хэрэгсэл байсан бөгөөд нийт автомашины 51,6% буюу 50 тээврийн хэрэгсэл хаягдал утааны агууламж өндөр ялгаруулж байна.<br>3.Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын хүрээнд 2023 оны 09 дүгээр сарын 06-аас 11-ний хооронд нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 5 аж ахуйн нэгж, байгууллагын 340 тээврийн хэрэгсэлд хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар илэрсэн зөрчилтэй аж ахуйн нэгжид Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу 500 нэгжийн торгуулийн арга хэмжээ ноогдуулж улсын байцаагчийн хугацаатай албан даалгавар болон улсын байцаагчийн акт хүргүүлсэн, Мөн 2 аж ахуйн нэгжид улсын байцаагчийн 1 заалттай 2 | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | албан шаардлагыг тус тус хүргүүлсэн. | |
| 10 | 4.2.10 | НХТЖҮЧ-5.2.2, НЗДҮАХ-5.2.3 ХАХТ-5.2.3.1 | Агаарын бохирдлын хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх хор уршиг, түүнийг бууруулах, угаарын хий, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэхийн тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар иргэн, хуулийн этгээдэд сургалт зохион байгуулж, зөвлөмж, сэрэмжлүүлэг хүргүүлнэ. | 2022 | НАОБТГ | Нийслэлийн төсөв | - | Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр олон нийтийн оролцоотой зохион байгуулах 10 арга хэмжээ хийсэн | Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр олон нийтийн оролцоотой зохион байгуулах 12 арга хэмжээг хийнэ. | 30.0 | 30.0 | Агаарын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, Засгийн газрын "Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай" 62, 223 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын А/1025 дугаар захирамжийн хүрээнд 2023.02.08- 02.20-ны өдрүүдэд 7 дүүргийн 1000 гаруй иргэн, хэсгийн ахлагч, зохион байгуулагч нарт угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдлээс хамгаалах сургалтыг дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, "Таван толгой түлш" ХХК-ийн Хэрэглэгчид үйлчлэх төвтэй хамтран зохион байгуулсан. Мөн тус захирамжийн хүрээнд гэр хороололд байршилтай 50 сургуулийн нийгмийн ажилтанд Нийслэлийн эрүүл мэндийн газар "Угаарын хийн хордлогоос урьчилан сэргийлэх зуухны стандартыг хангах", "Угаарын хийн хордлогын өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ", "Агаарын чанарын төлөв байдал, хэрэгжүүлж буй арга хэмжээ", "Зөв галлагаа" зэрэг сургалт, мэдээллийг Нийслэлийн Засаг захиргааны | 100% |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | 2 дугаар байранд зохион байгуулсан.<br>Мөн Нийслэлийн Засаг даргын 2023.09.06-ны өдрийн “Утаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, болзошгүй эрсдэлээс хамгаалах зарим арга хэмжээний тухай” А/1030 дугаар захирамжийн дагуу утаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, зөв гаргалгаа сэдэвт сургалтыг нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд байрлах 7 дүүргийн хэсгийн ахлагч, зохион байгуулагч, холбогдох төрийн албан хаагчид, иргэд олон нийтийн дунд 2023.09.25-10.09 хооронд зохион байгуулсан. Уг сургалтад 197 хорооны 2500 гаруй төрийн албан хаагч, иргэд олон нийт, Их дээд сургуулийн багш, оюутнуудыг хамруулсан.<br>Засгийн газрын 2022 оны 223 дугаар тогтоолоор Налайх дүүрэг нь агаарын чанарыг сайжруулах бүсэд орж, сайжруулсан шахмал түлш хэрэглэх болсонтой холбогдуулан тус дүүрэгт агаарын бохирдлын тасаг байгуулахад дэмжлэг үзүүлж хяналт мониторинг хийх зорилгоор 30 албан хаагчийн урамшууллын асуудлыг шийдвэрлэсэн. | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | Хамтран ажилладаг 4 телевиз, 10 сайт, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 6 төрлийн брошур, 5 төрлийн видео шторк, гэр хорооллын бүсэд байрлах ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдэд хичээл эхлэхийн өмнө 10 минутын угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх зөвлөмж, сэрэмжлүүлэг болон гэр хорооллын айл өрхүүдийн зуух, пийшингийн битүүмжлэлийн талаар зөвлөмж, сэрэмжлүүлгийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол иргэд, олон нийтэд хүргэн ажиллаж байна. | |
| 11 | 4.2.12 | НХТЖҮЧ-6.2.2, НЗДҮАХ-5.2.2 ХАХТ-5.2.5.1 | Нийслэлийн агаарын чанарын суурин автомат харуулын тоог нэмэгдүүлж хэмжилтийн үйл ажиллагааг өргөжүүлнэ | 2023 | НАОБТГ | Гадаадын тусламж | 1,000.0 | Автомат суурин станц 6 | 1 автомат суурин станцад оруулна. | 20.0 | - | Орчны агаарын чанарын хяналтыг сайжруулах ажлын хүрээнд 2023 онд орчны агаарын чанарыг 13 үзүүлэлтээр тодорхойлох 1 суурин харуулыг Бүгд Найрамдах Солонгос улс болон Монгол Улсын Засгийн Газрын гэрээгээр Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороо, Арцатын 624, Байгаль орчны шинжилгээ, судалгааны төв УТҮГ-ын хашаанд суурилуулан улсын нэгдсэн сүлжээнд холбон нийт 19 суурин харуулын мэдээг www.agaar.mn сайтаар иргэд | 100% |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | олон нийтэд мэдээлэн ажиллаж байна. | |
| 12 | 3 | НХТЖҮ 4.6.2.2, НХТХА Х-5.2.5 ХАХТ-5.2.5.3 | Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийг зохион байгуулж, мэдээллийн санг шинэчилнэ. | 2023 | Н-С Б ТГ | Нийслэлийн төсөв | - | 9 | 9 | 20.0 | 10.0 | Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогыг жил бүр хийдэг бөгөөд 2022-2023 оны агаарын бохирдлын эх үүсвэрийн тоо бүртгэл хийх ажлын хэсгийг Нийслэлийн Засаг даргын 2022.12.15-ны өдрийн А/1561 дүгээр захирамж, агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл хийх ажлын удирдамжийг батлуулсан. Тус ажлын хүрээнд Агаар бохирдуулагч эх үүсвэрийн бүртгэл тооллогыг батлагдсан [illegible] системд бүртгэлжүүлэн ажилласан. Тус ажлын хүрээнд 2022-2023 оны байдлаар 3-15квт хүчин чадалтай ахуйн хэрэглээний 162,552 зуух, 16-100 кВт хүчин чадалтай 3,751 зуух, 100 кВт-аас дээш хүчин чадалтай 353 усан халаалтын зуух, Дулааны цахилгаан 6 станцын 4200 кВт-аас дээш хүчин чадалтай 41 зуух, Агаарын бохирдлын хөдөлгөөнт эх үүсвэр нийт 655656 тээврийн хэрэгсэл тус тус тоологдож, мэдээллийн санг шинэчлэн ажилласан. Нийслэлийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 20-ны | 100% |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | өдрийн “Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл хийх тухай” А/1313 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт ажлын хэсэг байгуулан удирдамжийг батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | |

ТАНИЛЦСАН:
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.БАТШАГАЙ

ХЯНАСАН:
ДОТООД ХЯНАЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Г.ЭНХЖАРГАЛ

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:
МЭРГЭЖИЛТЭН Ц.БААСАНХҮҮ